

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
Эрдэм шинжилгээний бичиг

Боть XLIII

Улаанбаатар

2019

МОНГОР ХЭЛНИЙ ГИЙГҮҮЛЭГЧ АВИАЛБАРЫН ТУХАЙ

Хань Гуо Жюнь

Товч Агуулга: Тус өгүүлэлд “Монгор хэлний дуун ухааны зууч тооны дата хөмрөг”-т үндэслэн, дуун ухааны аргыг хэрэглэн монгор хэлний дан гийгүүлэгч авианы тоо хийгээд авиалах аргыг тогтоохын дагуу, авиалбар зүйн хураангуйлах аргыг хэрэглэж дан гийгүүлэгч авиалбар, авиалбарын хувилбар хийгээд түүний тохиолдох нөхцөлийг хураангуйлж, бүртгэл зүйн аргыг ашиглан нийлмэл гийгүүлэгчийн уялдлын тухай шинжилжээ. Үүнд монгор хэлэнд 23 дан гийгүүлэгч авиалбар, 31 нийлмэл гийгүүлэгчийн уялдал байна. Дан гийгүүлэгчийн хувилбар нь голдуу зэргэлдээ авианд шалтгаалагдсан нөхцөлт хувилбар болно хэмээн үзэв.

Түлхүүр үг: монгор хэл, гийгүүлэгч авиалбар, нийлмэл гийгүүлэгч, уялдал

Монгор хэлний дан эгшиг авиалбарын тухай цөөн хэдэн бүтээлд дурдаж өнгөрчээ. Үүнд дан гийгүүлэгч авиалбарын тоо хийгээд тэмдэглэх аргын талаар эрдэмтдийн үзэлт үндсэндээ нэгдэлтэй. Гэвч хувилбарын тэмдэглэх арга хийгээд тохиолдох нөхцөлийн тухай үндсэндээ дурдсангүй. Нийлмэл гийгүүлэгчийн уялдлын тухай өмнөх эрдэмтдийн нотлон тодорхойлолт нэгэн хэмжээнэ хариулт өгсөн боловч, бүртгэлийн тоо хийгээд нийлмэл гийгүүлэгчийн онцлог нь нэлээд зөрөөтэй, онцгойлон түүний уялдлын дүрмийн тухай үндсэндээ хүртсэнгүй. Үүний дагуу авиалагчийн адил бус, авиалах хурдцын адил бус ба зарим гийгүүлэгчийн уялдал бүрэлдэх шатандаа байгаагаас болсон зөрөө нь ч судлагч нарт баттай хариулт өгөхөд бэрх юм. Хүснэгт 1 бол адил бус эрдэмтдийн монгор хэлний нийлмэл гийгүүлэгчийн уялдлын тухай бүртгэл болно.

Хүснэгт 1

Зуун-Наст(1981)		Чингэлтэй(1991)		Ши Юань Линь(1986)		Stefan Georg(2003)	
Өмнөх гийгүүлэгч	Хойнох гийгүүлэгч	Өмнөх гийгүүлэгч	Хойнох гийгүүлэгч	Өмнөх гийгүүлэгч	Хойнох гийгүүлэгч	Өмнөх гийгүүлэгч	Хойнох гийгүүлэгч
s	k, q	S	p, k, q, ts, m, n	s	p, k, q, ts, m, n	s	p, t, k, q, ts, m
с	тс	с	q, тс, m, n	с	t, k, q, тс, n	с	тс
ш	p, t, k, q, ts	ш	t, k	ш	p, t, k, q, ts, n	ш	p, t, k, q, ts
x	k, q	X	k, q	x	t, k, q	x	k, q
n	t, t ^h , ts, ts, ts ^h , тс, тс ^h	N	p ^h , t, t ^h , ts ^h , тс, тс ^h , ts	n	t, t ^h , p, p ^h , k, k ^h , q, тс, тс ^h , ts	n	t, t ^h , тс, k, q

m	p, p ^h	M	p, k, k ^h , q	r	p, m, t, tɛ, ts, k, q		
ŋ	k, k ^h , q	᠓	k, q	f	n, l, k		
ɣ	p, k, q, t, ts, tɛ	R	p, t, k, q, ts, tɛ, m				

Өмнөх судалгаан дахь нийлмэл гийгүүлэгчийн уялдал

Нэг. Материалын ирэлт ба судалгааны арга

1. Материалын ирэлт

Тус удааны судалгаа нь “Монгор хэлний авианы дуун зууч тооны дата хөмрөг”-т илэрсэн бүх дан эгшгийг задалсан байна. Хөмрөгт нийт 1683 үгэнд гийгүүлэгч авиа илрэв. Үүнд дан үет үгэнд 203 удаа, хоёр үет үгэнд 1010 удаа, гурван үет үгэнд 449 удаа, дөрвөн үет үгэнд 21 удаа илэрсэн байна. Авиалбарыг хураангуйлах хэсэг нь дээрх материалын сууринд, “Монгол төрөл хэлний хэлний материалын хөмрөг”-ийн “Монгор хэлний хэлний материалын хөмрөг”-т илэрсэн 16000 гаруй үгсэд суурилжээ.

2. Судалгааны арга

Бид Монгор хэлний дан гийгүүлэгч авиалбарыг судлахдаа хамгийн тэргүүнд дуун ухааны аргыг хэрэглэж, монгор хэлний дан гийгүүлэгч авианы дууны өнгийг тодорхойлов. Дараа нь, гийгүүлэгч авианы хөмрөгт илэрсэн нийт тоог бүртгэхийн дагуу, адил бус байранд илэрсэн байдал, хамгийн бага эсэргүүцэлдэх үгс байх эсэх, илрэх нөхцөл зэрэг агуулгыг шинжилжээ. Үүнд хамгийн бага эсэргүүцэлдэх үгс байх эсэхээр авиалбарыг тогтоож, хөмрөгт илэрсэн нийт тоо, адил бус байранд илэрсэн байдал ба үгийн эхэнд дангаараа үе бүтээж болох эсэхээр төлөөлөгч хувилбарыг тогтоож, илрэх нөхцөлийн адил бусаар хувилбарын шинж чанарын тогтоожээ. Нийлмэл гийгүүлэгчийн уялдлын тухай голдуу бүртгэл зүйн аргыг ашиглав.

Хоёр. Судалгааны үр дүн

1. Дан гийгүүлэгч авиалбар

Монгор хэлэнд /p/, /p^h/, /t/, /t^h/, /k/, /k^h/, /q/, /f/, /s/, /s̥/, /ɕ/, /x/, /tɕ/, /tɕ^h/, /ts/, /ts^h/, /m/, /n/, /ŋ/, /l/, /ɭ/, /v/, /j/ зэрэг 23 дан гийгүүлэгч авиалбар бий. Хүснэгт 2 бол дан гийгүүлэгч авиалбар ба хувилбарын авиалах байрыг авиалах аргаар ангилсан хүснэгт болно.

Хүснэгт 2

		Хоёр уруулын	Уруул шүдний	Хэлний үзүүрийн	Хэлний өргөн талын	Хэлний угийн	Хүүхэн хэлний
Дуугүй	Хамжих+түрэлтгүй	/p/ [p̥]		/t/		/k/	/q/
	Хамжих+түрэлттэй	/p ^h /		/t ^h /		/k ^h /	
	Хамжин			/ts/	/tɕ/		
	шүргэх+түрэлтгүй			/ts ^h /	/tɕ ^h /		
	Хамжин шүргэх+ түрэлттэй						
	Шүргэх	[ɸ]	/f/	/s/ /s̥/	/ɕ/	/x/	[χ]
Дуутай	Шүргэх авиа	[β]		[ʒ]			[ɣ]
	Хамрын авиа	/m/		/n/		/ŋ/	
	Хажуугийн авиа			/l/			
	Доргих авиа			/ɭ/			
	Хагас эгшиг		/v/		/j/		

Монгор хэлний дан гийгүүлэгч авиалбар ба хувилбар

/p/: монгол хэлний /p/ авиалбарт [p], [β], [ф], [᠖] гэх дөрвөн хувилбар байна. Тус авиалбарын дөрвөн хувилбарын үгэнд илрэх байр ба илрэх норм нь бүр адил бус байдаг. Илрэх байрын талаар зөвхөн [p] хувилбар нь үгийн аливаа байранд илэрч болох мөртөө илрэх норм нь хамаг өндөр. Иймээс [p]-ээр төлөөлөгч хувилбар болгож, тус авиалбарыг тэмдэглэж, [β], [ф], [᠖] зэрэг гурван гийгүүлэгч нь нөхцөлт хувилбар болно.

[p]: төлөөлөгч хувилбар. Үгийн аливаа байранд бүр илэрч болох боловч голдуу үгийн эхэнд буюу үгийн дунд үеийн эхэнд илэрдэг. Жишээлбэл, bas [pɛs] (бар), bayaаn [pejɛ:n] (баян), bii [pi:] (битгий), bu [pu] (би), boosi [po:sə] (бөгөөс), humbaа [xʊmpɛ:] (умбах), simbee [sɛmpɛ:] (дээл), humbola [xʊmpʊlə] (хүлхэх), humbu [xʊmpu] (боох). Бас [s, ʂ, ʒ, m] гийгүүлэгч эхтэй нийлмэл гийгүүлэгчийн хойнох гийгүүлэгчийн байранд илэрдэг. Жишээлбэл, sbai [spɛi] (нохойн хошуу), gbaа [ʒpɛ:] (сорви), mbag [mpɛʒ] (хэвлэл), shbaawag [ʂpɛ:ʊlɔ] (мэлхий). Цөөн хэдэн үгэнд үгийн дунд үеийн сүүлд илэрдэг. Жишээлбэл, jublong [tɕopɭɔŋ] (зовлон), jibjig [tɕiptɕɛ] (шивэх), debtir [teptʰɛɣ] (дэвтэр), huribqi [xʊɣɛptɕʰə] (хуруувч).

[ф]: зэргэлдээ авианаас шалтгаалагдсан нөхцөлт хувилбар. Үгэнд илрэх байраас үзвэл зөвхөн үгийн дунд үеийн сүүл [s, ʂ] эхтэй үеийн өмнө илэрч, тус хоёр гийгүүлэгчийн нөлөөнөөс болж шүргэх гийгүүлэгч болсон байна. Жишээлбэл, dabsi [tɕfɕɛ] (давс), dabsag [tɕfɕɔɣ] (давсан), tabxi [tʰɕfɕɛ] (дэвсэх), debxir [tɕfɕiʒ] (төвшин), hambalabxi [ɕɛmβɛɕfɕɛ] (эрвээхэй).

[β]: зэргэлдээ авианаас шалтгаалагдсан нөхцөлт хувилбар. Илрэх байраас үзвэл үгийн дунд үеийн сүүлд [l, ʒ] эхтэй үеийн өмнө илэрнэ. Жишээлбэл, khabri [kʰɛ:βʒə] (хэврэг), tobla [tʰoβlə] (хүртэх), shgerli [xkɛβlə] (талархах).

[᠖]: зэргэлдээ авианаас шалтгаалагдсан нөхцөлт хувилбар. Үгийн дунд үеийн сүүлд [tɕ, tɕʰ, t] зэрэг хамжих буюу хамжин шүргэх гийгүүлэгч эхтэй үеийн өмнө илэрдэг. Энэ нь голдуу тус хамжих гийгүүлэгч ба хойнох хамжих буюу хамжин шүргэх гийгүүлэгчийн саад бүрэлдэх хэсэг нь давхацсанаас болсон юм. Жишээлбэл, gaagabqi [kɕkɕɛptɕʰə] (чигчий хуруу), qabji [tɕʰɕɛptɕɛ] (цавч), tibdee [tʰɕɛptɕɛ:] (дэвтээх), shgebqi [ʂkɕɛptɕʰə] (эрхий хуруу).

/p/ авиалбарын хувилбарын илрэх байр ба нөхцөлийг загварчилбал доорх мэт:

[p] → [ф] / + [s, ʂ]

[p] → [β] / + [l, ʒ]

[p] → [᠖] / + [tɕ, tɕʰ, t]

/Pʰ/: голдуу үгийн эхэнд дан гийгүүлэгчийн хэлбэрээр илэрдэг. Жишээлбэл, pagda [pʰɔɣtɕ] (багтаах), piile [pʰi:le] (үлээх), pusee [pʰuse:] (бүс), posghu [pʰosɣʊ] (бошго). Зарим цөөн үгэнд нийлмэл гийгүүлэгчийн хойнох гийгүүлэгчийн байранд буюу үгийн дунд үеийн эхэнд илэрдэг. Жишээлбэл, mreele [mpʰɛ:le] (хөгжих), nimpu [nɛmpʰu] (нулимах), nimpusi [nɛmpʰəsɛ] (нулимс).

/t/: үгийн эхэнд дан гийгүүлэгч ба нийлмэл гийгүүлэгчийн хойнох гийгүүлэгчийн хэлбэрээр илрэх буюу үгийн дунд үеийн эхэнд илэрдэг. Үүнд үгийн дунд үеийн эхэнд илрэх норм нь хамгийн өндөр. Жишээлбэл, daaha [tɕ:xɛ] (даага), duraan [tuʒɛ:n] (дур), ndasi [ntɕɛsɛ] (ундаасах), shdaа [ʂtɕɛ:] (шатаах), kɕtesɛ [kɕtesɛ] (гэдэс), idexi [itɕɛsɛ] (идэш).

/tʰ/: үгийн эхэнд дан гийгүүлэгч ба нийлмэл гийгүүлэгчийн хойнох гийгүүлэгчийн хэлбэрээр илрэх буюу үгийн дунд үеийн эхэнд илэрдэг. Үүнд үгийн эхэнд илрэх норм нь хамгийн өндөр. Жишээлбэл, toolii [tʰo:li:] (туулай), tulum [tʰulum] (тулам), ntiraa [ntʰɕʒɛ:] (унтах), radi [pɛtʰɛ] (бат), amata [ɛmɔtʰɛ] (амт).

/k/: үгийн эхэнд дан гийгүүлэгч ба нийлмэл гийгүүлэгчийн хойнох гийгүүлэгчийн хэлбэрээр илрэх буюу үгийн дунд үеийн эхэнд илэрдэг. Үүнд үгийн эхэнд илрэх норм нь хамгийн өндөр. Жишээлбэл, ger [kɕʒ] (гэр), gidai [kɕtɛ:] (гэдийх), gidesi [kɕtesɛ] (гэдэс), nige [nikɕ] (нэг), oosgi [o:sku] (уушги), helge [xɛlkɕ] (алга), sge [ske] (уулзах), shge [ʂke] (их).

/k^h/: үгийн эхэнд дан гийгүүлэгч ба нийлмэл гийгүүлэгчийн хойнох гийгүүлэгчийн хэлбэрээр илрэх буюу үгийн дунд үеийн эхэнд илэрдэг. Үүнд үгийн эхэнд илрэх норм нь хамгийн өндөр. Жишээлбэл, *kii* [k^hi:] (хий), *nkurlo* [ŋk^hoɾlo] (хүрд), *nuko* [nuk^ho] (нүх).

/q/ авиалбарт [q], [χ], [ɣ] гэх гурван хувилбар байна. Үүнд үгийн эхэнд илэрдэг мөртөө илрэх норм нь хамгийн өндөр [q]-ээр төлөөлөгч хувилбар болгож, тус авиалбарыг тэмдэглэж, [χ], [ɣ] хоёр гийгүүлэгч нь нөхцөлт хувилбар болно.

[q]: голдуу үгийн эхэн ба үгийн дунд илэрдэг. Үгийн эхэнд дан гийгүүлэгчийн хэлбэр ба [s, x, ʒ] зэрэг гийгүүлэгчтэй уялдсан нийлмэл гийгүүлэгчийн хойнох гийгүүлэгчийн хэлбэрээр илэрдэг. Жишээлбэл, *ghal* [qel] (гал), *sghal* [sqel] (сахал), *hghua* [χque] (хуваах), *nghuasi* [ŋquɐsɛ] (унгас). Үгийн дунд голдуу өргөлт үеийн эхэнд илэрдэг. Жишээлбэл, *asghu* [ɛsɣu] (зээлэх), *arilgha* [ɛɾɪlqɛ] (арилгах), *muriidilgha* [mɛɾi:tɪlqɛ] (мурийлгах).

[ɣ]: Үгийн дунд өргөлт бус үеийн эхэнд илэрдэг. Тийм мөртөө өмнөх үе нь эгшгээр төгсөх буюу [n, ŋ, l, ɾ, ʒ] зэрэг дуутай гийгүүлэгчээр төгсдөг. Жишээлбэл, *dughulong* [tɒɣɒlɒŋ] (догolon), *balghasi* [pɛlɣɐsɛ] (балгас), *tangula* [t^hɛŋɣɒlɛ] (тэднүүс). Зарим байдалд үеийн эцэст [m, l, ɾ] зэрэг дуутай гийгүүлэгчийн өмнө илэрдэг. Жишээлбэл, *jogmu* [tɛɣɪmu] (ганга), *xogla* [ɛɣɪlɛ] (үргэх), *qagraa* [tɛ^hɣɪɣɛ:] (дуудах).

[χ]: Үгийн дунд өргөлтөт бус үеийн эхэн, эцэс ба үгийн эцэст илэрдэг. Өргөлтөт бус үеийн эхэнд [ɣ] авиатай чөлөөтэй сэлгэгддэг. Жишээлбэл, *daghaajin* [tɛɣɛ:teɪn] (дагагсад), *aghadiu* [ɛɣɛtiɯ] (ах дүү), *turoldhajin* [t^hɛɾɪlɣɛteɪn] (эх баригч). Үеийн эцэст [t, tɛ, tɛ^h, ts, s, ʂ] зэрэг гийгүүлэгч эхтэй үеийн өмнө илэрнэ. Жишээлбэл, *nogdoo* [nɒɣto:] (ногт), *xogqan* [ɛɣɣtɛ^hɛn] (хөгжөөн), *sogsog* [sɒɣsɒɣ] (сүрэг). /q/ авиалбар үгийн эцэст нийдэмдээ [χ] гийгүүлэгчээр илэрдэг. Жишээлбэл, *arag* [ɛɣɣɣ] (агар), *aradag* [ɛɣɣɣɣ] (ардар), *bumbulog* [pʊmpʊlɒɣ] (бутан).

/q/ авиалбарын хувилбарын илрэх байр ба нөхцөлийг загварчилбал доорх мэт:

$$[q] \rightarrow [ɣ] \left\{ \begin{array}{l} [V, n, \eta, l, \mathfrak{r}, ʒ] + _ \\ _ + [m, l, \mathfrak{r}] \end{array} \right\}$$

$$[q] \rightarrow [\chi] \left\{ \begin{array}{l} V + _ \\ _ + [t, tɛ, tɛ^h, ts, s, ʂ] \\ V \# \end{array} \right\}$$

/f/: голдуу үгийн эхэнд илэрдэг. Жишээлбэл, *foodi* [fo:tɛ] (од), *fumugii* [fumuki:] (өмхий). Үгийн дунд зөвхөн *roofoaraa* [p^ho:fɛɾɛ:] (зовох) гэдэг нэг л үгэнд тохиолджээ.

/s/: үгийн эхэнд дан гийгүүлэгчийн хэлбэр ба нийлмэл гийгүүлэгчийн өмнөх гийгүүлэгчийн хэлбэрээр илэрдэг. Жишээлбэл, *suu* [su:] (суга), *sam* [sɛm] (сам), *szin* [stsɛn] (ес), *sgii* [ski:] (эсгий). Үгийн дунд үеийн эхэнд илэрдэг. Жишээлбэл, *oosgi* [o:sku] (уушги). Үгийн эцэст илрэхдээ зөвхөн дан үет үгэнд илэрдэг. Жишээлбэл, *bas* [pɛs] (бар), *bos* [pus] (бөс), *jas* [tɛɛs] (зэс).

/ʂ/: голдуу үгийн эхэнд нийлмэл гийгүүлэгчийн өмнөх гийгүүлэгчийн хэлбэрээр илэрдэг. Жишээлбэл, *shda* [ʂtɛ] (чадах), *shdi* [ʂtɛ] (шүд), *shdoogu* [ʂto:ku] (өтлөө). Цөөн хэдэн үгэнд үгийн эхэн ба үгийн дунд илэрдэг. Жишээлбэл, *shauda* [ʂɣute] (хатгах), *mashdaa* [mɛʂtɛ:] (мартах), *araa shdi* [ɛɣɛ:ʂtɛ] (араа шүд).

/ɛ/: үгийн эхэнд дан гийгүүлэгчийн хэлбэр ба нийлмэл гийгүүлэгчийн өмнөх гийгүүлэгчийн хэлбэрээр илэрдэг. Жишээлбэл, *xini* [ɛinɛ] (шинэ), *ximu* [ɛimu] (шимэх), *xjau* [ɛtɛɣu] (цээж). Үгийн дунд голдуу үеийн эхэнд илэрч, цөөн байдалд үеийн эцэс ч илэрдэг. Жишээлбэл, *haxin* [xɛɪn] (гашуун), *idexi* [itɛɛ] (идэш), *muxgi* [muɛkɛ] (мушгих).

/x/: үгийн эхэнд дан гийгүүлэгчийн хэлбэр ба нийлмэл гийгүүлэгчийн өмнөх

гийгүүлэгчийн хэлбэрээр илэрдэг. Жишээлбэл, ham [xəm] (гутал), hara [xəɣə] (хар), huri [xuɣə] (хуруу), hghur [xquɣ] (охор), hghala [xqələ] (хаях), hghai [xqzi] (гахай). Үгийн дунд зөвхөн үеийн эхэнд илэрдэг. Жишээлбэл, maha [mɛxə] (мах), mauhan [mɔuxən] (муухай), daaha [tɛ:xə] (даага).

/tɛ:/ үгийн эхэнд дан гийгүүлэгчийн хэлбэр ба нийлмэл гийгүүлэгчийн хойнох гийгүүлэгчийн хэлбэрээр илэрч, үгийн дунд зөвхөн үеийн эхэнд илэрдэг. Үүнд үгийн дунд илрэх норм нь хамгийн өндөр. Жишээлбэл: ghaja [qetɛv] (хазах), gujee [kutɛ:] (гүжээ), ujuur [utɛu:ɣ] (үзүүр), juu [tɛu:] (зүү), jiran [tɛiɣən] (жар), xjau [ɛtɛzu] (цээж), njasi [ntɛsə] (анжис), rjee [ɣtɛ:] (мөр).

/tɛʰ:/ үгийн эхэнд дан гийгүүлэгчийн хэлбэр ба нийлмэл гийгүүлэгчийн хойнох гийгүүлэгч хэлбэрээр илэрч, үгийн дунд зөвхөн үеийн эхэнд илэрдэг. Үүнд үгийн эхэнд дан гийгүүлэгчийн хэлбэрээр илрэх норм нь хамгийн өндөр. Жишээлбэл, qi [tɛʰə] (чи), qadi [tɛʰɛtə] (цадах), qasi [tɛʰɛsə] (цас), aaqi [v:tɛʰə] (ач), muqin [muteʰin] (мич), aasinqi [v:səntɛʰə] (адуучин), nqam [nteʰəm] (цам), nqimla [nteʰimlə] (захирах).

/tɛ:/ үгийн эхэнд дан гийгүүлэгчийн хэлбэр ба нийлмэл гийгүүлэгчийн хойнох гийгүүлэгч хэлбэрээр илэрч, үгийн дунд зөвхөн үеийн эхэнд илэрдэг. Үүнд үгийн эхэнд нийлмэл гийгүүлэгчийн хойнох хэлбэрээр илрэх норм нь хамгийн өндөр. Жишээлбэл, үгийн эхэнд дан гийгүүлэгчийн хэлбэр ба нийлмэл гийгүүлэгчийн хойнох гийгүүлэгч хэлбэрээр илэрч, үгийн дунд зөвхөн үеийн эхэнд илэрдэг. Үүнд үгийн эхэнд дан гийгүүлэгчийн хэлбэрээр илрэх норм нь хамгийн өндөр. Жишээлбэл, zooha [tso:xə] (зуух), zandan [tsəntən] (зандан), szin [stsən] (ес), szu [stsɔ] (үс), rzii [rtsi:] (ярзайх), kuizi [kʰuitsə] (хүйс), suulzi [su:ltɛsə] (сөс), boorzog [po:ɣtsəx] (боорцог).

/tɛʰ:/ олонх байдалд зээлээ үгэнд илэрч, уугуул үгэнд зөвхөн нийлмэл гийгүүлэгчийн хойнох гийгүүлэгчийн хэлбэрээр илэрдэг. Жишээлбэл, cai [tɛʰzi] (ногоо), cooki [tsʰo:kə] (зүлгэх), ncogla [ntsʰəɣlə] (цугларх).

/n:/ үгэнд аливаа байранд бүр илэрч болдог мөртөө нийлмэл гийгүүлэгчийн өмнөх гийгүүлэгчийн хэлбэрээр илрэх үед чөлөөтэй гээгдэж болдог. Жишээлбэл, neaten [ne:tʰən] (нойтон), ndasi [ntɛsə] (ундаасах), soni [sonə] (шөнө), udaandi [utɛ:ntə] (удаашпах), szin [stsən] (ес).

/m:/ үгийн аливаа байранд бүр илэрч болдог. Үгийн эхэнд илрэх үед дан гийгүүлэгч хэлбэр, нийлмэл гийгүүлэгчийн өмнөх гийгүүлэгчийн хэлбэр ба хойнох гийгүүлэгчийн хэлбэрээр илэрч, үгийн дунд үеийн эхэн ба сүүлд бүр илэрдэг. Жишээлбэл, mara [mɛɣə] (мариа), mpɛɛle [mpʰɛ:le] (хөгжих), smambaa [smɛmpɛ:] (эмч), ama [ɛmɛ] (ам), humbaa [xumɛpɛ:] (умбах), sam [səm] (сам).

/ŋ:/ үгийн эхэн, дунд, адагт бүр илэрдэг. Үүнд үгийн эхэнд зөвхөн нийлмэл гийгүүлэгчийн өмнөх гийгүүлэгчийн хэлбэрээр илэрдэг мөртөө чөлөөтэй гээгддэг. Жишээлбэл, ngo [ŋkɔ] (өнгө), nghusi [ŋquɣsə] (унгас), ningen [niŋken] (нимгэн), tanglii [tʰŋli:] (тагнай), ulong [ulɔŋ] (үүл), dong [tɔŋ] (дун).

/l:/ үгийн аливаа байранд бүр илэрч болдог. Үүнд үгийн дунд үеийн эхэнд илрэх норм нь хамгийн өндөр. Үгийн дунд илрэх үед өмнөх үе нь заавал эгшгээр төгссөн байх ёстой. Хэрвээ тус гийгүүлэгч нь залгаврын эхэнд илрэх үед өмнөх үе нь заавал эгшиг, эсвэл [m, n, ŋ, ɣ] зэрэг дуутай гийгүүлэгч ба [q]-ээр төгсдөг. Үгийн дунд үеийн эцэст илрэх үед дараачийн үе нь заавал [t, q, k, tɛ, tɛʰ] зэрэг хамжих буюу хамжин шүргэх гийгүүлэгчээр эхэлдэг. Жишээлбэл, losi [losə] (өлсөх), kile [kʰələ] (хэлэх), deelge [tɛ:lke] (дээс), sghal [sqəl] (цахал).

/j:/ үгийн эхэн ба үгийн дунд үеийн эхэнд илэрдэг. Үүнд үгийн эхэнд илрэх норм нь өндөр. Жишээлбэл, yeruu [jɛzu:] (эрүү), yirin [jirɛn] (ер), fuyaa [fujɛ:] (уях), buye [pujɛ:] (бие).

/v:/ үгийн эхэнд ба үгийн дунд үеийн эхэнд илэрдэг. Жишээлбэл, warong [vɛɣŋ] (баруун), wer [vɛɣ] (эвэр), xawar [ɛvɛɣ] (шавар), taawun [tʰv:vun] (тав).

/ɣ/: авиалбарт [ɣ], [ʒ] зэрэг хоёр чөлөөт хувилбар байдаг. Үүнд үгийн аливаа байранд бүр илэрдэг мөртөө илрэх норм нь өндөр [ɣ]-ээр төлөөлөгч хувилбар болгож, тус авиалбарыг тэмдэглэв.

[ɣ]: үгийн эхэн, дунд, адагт бүр илэрдэг. Үүнд үгийн эхэнд нийлмэл гийгүүлэгчийн өмнөх гийгүүлэгчийн хэлбэрээр илэрч, үгийн дунд үеийн эхэн ба эцэст бүр илэрдэг. Жишээлбэл, rgul [ɣkʊl] (өвөл), haraa [xəɣe:] (хараах), ardagha [əɣtəqə] (аргадах), niur [niɣɣ] (нүүр).

[ʒ]: үгийн эхэн ба дунд илэрдэг. Үүнд үгийн эхэнд дан гийгүүлэгчийн хэлбэр ба нийлмэл гийгүүлэгчийн өмнөх гийгүүлэгчийн хэлбэрээр илэрч, үгийн дунд үеийн эхэн ба эцэст бүр илэрдэг. Жишээлбэл, ramda [ʒəmtə] (жолоо), rdem [ʒtem] (эрдэм), gurimal [kuʒmɛl] (гөрмөл), far [fəʒ] (өт), buruu [pəʒu:] (бяруу).

2. Нийлмэл гийгүүлэгч

Монгол хэлний үгийн эхэнд нийлмэл гийгүүлэгч нэлээд бий. Түүний бүрэлдлийн тухай эрдэмтэд санал нэгтэй, даруй монгол хэлний үгийн өргөлт эцсийн үедээ байдаг учраас үгийн эхний эгшиг балархайших, анирших, цаашлаад сугаран гээгдэх мэтийн явцыг өнгөрөөж, нийлмэл гийгүүлэгчдийг бүрэлдүүлээ хэмээж бий. Бас зарим эрдэмтдийн үзэхээр, авианы улиралт нь ч нийлмэл гийгүүлэгч бүрэлдэхийн нэг шалтгаан болох юм гэв. Үүнд дурдаж байгаа авианы улиралт нь эгшиг авиа гийгүүлэгч авиа болж хувирахыг хэлдэг. Жишээлбэл, ʂtəʂə (утас) гэх үгийн ʂ гийгүүлэгч нь u-ээс ирэлттэй гэж бий. Хүснэгт 3 бол тус удааны судалгааны монгол хэлний нийлмэл гийгүүлэгчийн уялдлын бүртгэл болно.

Хүснэгт 3

Өмнөх гийгүүлэгч		Хойнох гийгүүлэгч
Дуугүй шүргэх авиа	s	ts /k, q/ p, m, n
	ɕ	tɕ
	ʃ	t /k/ q
	x	q / k
Дуутай хамжих авиа	(n)	t / tɕ, tɕʰ / tʰ, tsʰ
	(m)	p, pʰ
	(ŋ)	k / q / kʰ
	ʒ	ts / t, tɕ, k / p, q, l
Доргих авиа	ɣ	k / t

Монгол хэлний нийлмэл гийгүүлэгчийн уялдал

Хүснэгтээс мэдэх нь:

1. Монгол хэлний нийлмэл гийгүүлэгч үгийн эхэнд олон илэрнэ. Залгавар залгах тохиолдолд, үгийн дунд бас хааяа илэрнэ. Энэ нь монгол хэлний үгийн өргөлт нь эцсийн үедээ байж, үгийн эхний үе сул авиалагдахтай холбоотой байдаг.

2. Гэвч үг болгоны эхний үед нийлмэл гийгүүлэгч илэрдэг биш, адил бус гийгүүлэгч нь нийлмэл гийгүүлэгч болж уялдахдаа заавал тогтсон авианы уялдах дүрэм горимыг сахидаг. Үүнийг гурван талаас хураангуйлж болно.

(1) Дуугүй шүргэх гийгүүлэгч ба түрэлтгүй хамжих гийгүүлэгч (хамжин шүргэх), хамрын гийгүүлэгчийн уялдал. Тус уялдал нь тогтворт уялдлын хэлбэрт тооцогдоно, хоёр гийгүүлэгчийн хэлний байр ойролцоо байх нь уялдлын дэд нөхцөл болно. (Хүснэгт 3-т / тэмдгээр хэлний байр нь ойролцоо байгааг тодорхойлж, уялдлын давтамжийн өндрөөс доош дараалан жагсаав) өмнөх гийгүүлэгч нь тустаан авиалбарын чадамжтай байж, бусад авиагаар солих буюу орхигдуулж болохгүй.

(2) Хамрын гийгүүлэгч ба хамжих (хамжин шүргэх) гийгүүлэгчийн уялдал. Тус уялдал нь тогтворт бус уялдалд тооцогдоно, өмнөх гийгүүлэгч нь сугаран гээгдэж болно (Хүснэгт 3-т () тэмдгээр тодорхойлов). Хоёр гийгүүлэгчийн хэлний байр ойролцоо байх нь уялдлын дэд нөхцөл болно.

(3) Хэлний үзүүрийн чичрэх гийгүүлэгч ба түрэлтгүй хамжих (хамжин шүргэх) гийгүүлэгчийн уялдал. Хоёр гийгүүлэгчийн хэлний байр ойролцоо байх нь уялдлын дэд нөхцөл болно.

Авианы түүхэн хувиралтаас ажвал, дуугүй шүргэх авиа ба хамжих (хамжин шүргэх) авианы уялдал нь өмнөх гийгүүлэгчийн ар дахь эгшгийн аниршил буюу сугарлаас болсон нь илэрхий, даруй сул авиалагдах байрын эгшгийн аниршлын үр дүн болох юм. Жишээлбэл: *sexel* (сахал)→*sqel*, *ʂitu* (шүд)→*ʂtə*, *qexei* (гахай)→*xqai*, *untekə* (өндөг)→*ntəke*, *uŋkusə* (унгас)→*ŋkəvsə* зэрэг.

Авиалбарын уялдлын онцлогоос харахад, дуугүй шүргэх авиа ба хамжих (хамжин шүргэх) авианы уялдал нь уртлах авиа ба хором авианы уялдал болох юм, даруй чанга гийгүүлэгч ба сул гийгүүлэгчийн найрал болно. Бүтцийн ирэл гарлаас үзвэл, тэр нь үеийн дотоод дахь авианы уялдал буюу хувиралтын харьяанд багтана. Дуутай гийгүүлэгч ба хамжих (хамжин шүргэх) гийгүүлэгчийн уялдал нь дуутай гийгүүлэгч ба хором гийгүүлэгчийн уялдал болно, мөнхүү чанга гийгүүлэгч ба сул гийгүүлэгчийн уялдлын цар хүрээнд харьяалагдана.

Бүтцийн ирэл гарлаас шинжилбэл, эдгээр нийлмэл гийгүүлэгч нь үеийн заагийн хоорондох авианы уялдлаас бүтсэн нийлмэл гийгүүлэгч болно, тиймээс түүний уялдал нь үеийн дотоод дахь авианы уялдлаас бүтсэн нийлмэл гийгүүлэгчийг бодвол арай тогтвортой биш, өмнөх гийгүүлэгч нь сугаран гээгдэж болно, энэ нь түүний авиалбарын чадамжаа алдаж байгаагийн шууд илрэл болно.

(Нэг) Аниргүй шүргэх гийгүүлэгч + түрэлтгүй хамжих гийгүүлэгч (хамжин шүргэх)

1. [s]-аар эхэлбэртэй нийлмэл гийгүүлэгч

[s] нь [p], [k], [q], [ts], [m], [n] зэрэг гийгүүлэгчтэй уялдаж нийлмэл гийгүүлэгчийг бүрэлдүүлдэг. Үүнд [sp], [sk], [sq], [sts] дөрвөн төрөл нь харьцангуй тогтвортой, [sm] ба [sn] хоёр нь тогтворт чанараар аанай. [s]-ийн ард зарим үед эгшиг нь сэргэж, зарим үед арилдаг, иймээс зарим эрдэмтэд нийлмэл гийгүүлэгчид [sm], [sn] байна гэхэд зарим нь үгүй гэдэг. Дээр дурдсан нийлмэл гийгүүлэгчүүд дата хөмрөгт нийт 53 удаа, өвчдөө үгийн эхэнд илрэв. Үүнд [sts]-ийн давтамж хамгийн өндөр, 25 удаа, дараалбал [sk], [sq] тус тус 17 ба 8 удаа, [sp], [sm] ба [sn] гурав цөөн хэдхэн үгэнд л илрэв. Жишээлбэл: *stsu* (ус), *squr* (сохор), *skə* (сахь), *spzi* (нохойн хошуу), *smempe*: (эмч), *sne:etee* (буйл).

2. [ʃ]-аар эхэлбэртэй нийлмэл гийгүүлэгч

[ʃ] нь [tʃ]-тай уялдан нийлмэл гийгүүлэгчийг бүрэлдүүлдэг, тогтвортой уялдалд багтана. Дата хөмрөгт нийт 28 удаа илэрч, олонхдоо үгийн эхэнд (24 удаа), цөөн тохиолдолд үгийн дунд (4 л удаа) илэрнэ. Жишээлбэл: [ʃtee:] (ич), [nʊxʃteil] (аянгат бороо).

3. [ʂ]-аар эхэлбэртэй нийлмэл гийгүүлэгч

[ʂ] нь [t], [k], [p]-тай уялдан нийлмэл гийгүүлэгчийг бүрэлдүүлдэг, тогтвортой уялдалд

багтана, дата хөмрөгт нийт 52 удаа, нийдэмдээ үгийн эхэнд илэрчээ. [st] гэх хэлбэр нь дийлэнх тоог эзлэн 44 удаа илэрч, [sk] ба [sp] тус тус 7 ба 1-ийн давтамжтай. Жишээлбэл: [ste] (чад), [ske] (их), [spe:vlx] (мэлхий).

4. [x]-аар эхэлбэртэй нийлмэл гийгүүлэгч

[x] нь [k], [q]-тай уялдан нийлмэл гийгүүлэгчийг бүрэлдүүлдэг, тогтвортой уялдалд багтана. Дата хөмрөгт нийт 23 удаа, нийдэмдээ үгийн эхэнд илэрчээ. [xq]-гийн давтамж 18-д хүрч, [xk] 5 удаа илрэв. Жишээлбэл: [xqεε:] (хагар), [xkəle] (ав).

(Хоёр) Хамрын гийгүүлэгч + хамжих гийгүүлэгч

Эдгээр нийлмэл гийгүүлэгчийн чухал нэг онцлог бол өмнөх ба хойнох гийгүүлэгчийн хэлний байр нь ижилхэн байгаад оршино.

1. [n]-ээр эхэлбэртэй нийлмэл гийгүүлэгч

[n] нь [t], [tʰ], [te], [teʰ], [tsʰ] зэрэг гийгүүлэгчтэй уялдаж нийлмэл гийгүүлэгчийг бүрэлдүүлдэг, тогтворт бус уялдалд харьяалагдана, олонх байдалд өмнөх [n] нь сугаран гээгддэг. 31 удаа илэрсэн тохиолдолд нийдэмдээ үгийн эхэнд байв. [nt] хамаг олон давтамжтай, нийт 11 удаа, дараалбал [ne], [nteʰ] тус тус 10 ба 9 удаа, гуравдугаарт [ntʰ], [ntsʰ] тус тус 1 ба 2 удаа. Жишээлбэл: [ntesə] (ундас), [nteεsə] (анжис), [nteʰi:le] (бүхий), [ntʰεε:] (унтар), [ntsʰəle] (хур).

2. [m]-аар эхэлбэртэй нийлмэл гийгүүлэгч

[m] эхэлбэртэй нийлмэл гийгүүлэгч цөөн тохиолдолтой, дата хөмрөгт [mpeɜ] (хэвлэ), [mpe:ɜ] (хөгж) гэх хоёрхон үгэнд илэрсэн мөртөө, [m] нь авиалагдахгүй байсан ч болно.

3. [ŋ]-ээр эхэлбэртэй нийлмэл гийгүүлэгч

[ŋ] нь [k], [kʰ], [q]-тай уялдан нийлмэл гийгүүлэгчийг бүрэлдүүлнэ, тогтворт бус уялдал, [ŋ] нь сугаран гээгдсэн ч үгийн утгыг нөлөөлөхгүй, үгийн эхэнд л илэрдэг. Дата хөмрөгт 19 удаагийн давтамжтай, [ŋk] хэлбэрээр 11 удаа, [ŋkʰ]-ээр 3 удаа, [ŋq]-аар 5 удаа тус тус илрэв. Жишээ үгийг жагсаавал: [ŋko] (өнгө), [ŋqoesə] (унгас), [ŋkʰoŋlo] (хүрд).

4. [z]-ээр эхэлбэртэй нийлмэл гийгүүлэгч

[z] нь [p], [t], [k], [q], [te], [ts], [l] зэрэг гийгүүлэгчтэй уялдаж нийлмэл гийгүүлэгчийг бүрэлдүүлдэг, тогтворт бус уялдал, [z]-ийн ард заримдаа эгшиг жийрэглэдэг, үгийн эхний үед л илэрнэ. Дата хөмрөгийн бүртгэлд 24 удаагийн давтамжтай, үүнд [ts]-тай уялдсан нь хамгийн олон, нийт 6 удаа, [t], [te], [k] уялдсан нь тус тус 5, 5, 4 удаа, [p], [q], [l]-тай уялдсан нь харьцангуй цөөн, тус тус 2, 1, 1 удаа. Жишээлбэл: [zklŋ] (уул, орой), [rtsi:] (иржээ), [zlen] (нойтон), [ztemti:] (эрдэмтэй), [zpele] (шалбалах), [zteε:le] (давах, ялах) .

(Гурав) Хэлний үзүүрийн чичрэх гийгүүлэгч + түрэлтгүй хамжих гийгүүлэгч

[ɾ] нь [t], [k]-тай уялдан нийлмэл гийгүүлэгчийг бүрэлдүүлнэ, тогтворт бус уялдал, дунд нь хааяадаа эгшиг жийрэглэдэг, дата хөмрөгт нийт 7 удаа, нийдэмдээ үгийн эхэнд илэрчээ. Үүнд [ɾt] гэх хэлбэрээр 6 удаа, [ɾk] гэх хэлбэрээр гагцхан удаа илрэв. Жишээлбэл: [ɾkul] (өвөл), [ɾtompən] (чулуун овоо).

Нийлмэл гийгүүлэгчийн уялдлын дүрмээс монгол хэлний гийгүүлэгчийг авиалбар зүйн үүднээс эсэргүүцэлдэн байрших хоёр их серид хуваан үзэж болно, тэр нь даруй уртлах гийгүүлэгч ба хором гийгүүлэгч болох юм, шүргэх гийгүүлэгч ба дуутай гийгүүлэгч нь уртлах гийгүүлэгчийн харьяанд багтаж, хамжих гийгүүлэгч нь хором гийгүүлэгчид багтана, өмнөх нь чанга гийгүүлэгч байж, хойнох нь сул гийгүүлэгч болох юм.

ON THE CONSONANT PHONEMES IN MONGUOR LANGUAGE

Based on *The Database of Acoustic Intermediate Numbers of Monguor Language*, this paper ascertains the amount and the articulation manner of the single consonants in Monguor Language by using acoustic methods, summarizes the single consonant phonemes, phoneme variants and their variation condition by using generalizing method, and studies the combination of compound consonants by using statistical method. There are 23 single consonant phonemes, 31 combinations of compound consonants in Monguor Language. The variants of single consonants belong to conditional change caused by adjacent phonemes.

Key words: Monguor Language; consonant phoneme; compound consonant; combination

Номзүй

- Сүнь-Жуу.** 1990. *Монгол төрөл хэлний толь*. Хөхнуурийн ардын хэвлэлийн хороо.
- Зууннаст.** 1981. *Монгол хэлний ойлбор*. Үндэстний хэвлэлийн хороо.
- Чингэлтэй.** 1991. *Монгол хэл ба монгол хэл*. Өвөр Монголын хэвлэлийн хороо.
- Ши Юань Линь.** 1986. *Монгол хэлний авиалбарын систем*. Дундад улсын үндэстний хэлний өгүүллийн түүвэр. Сичуань үндэстний хэвлэлийн хороо.
- Juha Janhunen.** 2003. *The Mongolic languages*. Routledge. London and New-York.